



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/194

Жавхлант

Хорио цээрийн дэглэмийг чангатгаж,
Хил хязгаарыг тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.11, гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.1, 23.1, 32.1.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16 дугаар зүйлийн 16.1.2, 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, ЗЗасгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолыг тус тус үндэслэн захирамжлах нь

1.Тус сумын Дэлгэрхаан багийн малчин П.Оюунбатын суурьт гоц халдварт шүлхий өвчин 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 25-6378 тоот шинжилгээний дүнгээр тогтоогдсон 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/181 дугаар захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон бүсийн хязгаарыг наливчлан гаргаж хавсралтаар баталсугай.

2.Тухай нутагт дэвсгэрт нийтийн хэв журмын хамгаалах олон нийтийн аюулгүй байдал хангах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч(Б.Ганбаяр)-д даалгасугай.

3.Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан малчид, мал бүхий иргэдэд өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд харьяалах мал эмнэлэг, сумын мал эмнэлгийн тасагт мэдэгдэх, мал сүргээ байнгын хариулгатай байлгаж бусад айлын малтай нийлүүлэхгүй байх, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд шилжилт хөдөлгөөн хийхгүй байхыг үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ЗДТГ-н дарга М.Шаравгаваа үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ЦОЛМОНБАЯР